



# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 11 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү тогтоолоор баталсан журмыг үндэслэн хуульд засан хөнгөлөлт эдлэх нөхцөлийг хангасан ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх ажлыг зохион байгуулж, уг ажлын үр дүнг 2012 оны нэгдүгээр улиралд багтаан танилцуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ч.Алтанхуяг)-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Х.Алимаа)-нд даалгасугай.

Дөрөв. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2011 оны 13 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Д.НЯМХҮҮ



Сургаа, Ажилтнээдийн даатгалын шимтгэлийн хөтөлбөрээс узүүлэх болзох нийцэл  
Ажлын байрыг төгвөртөй хөдлөлтэй цэвэр 6 жилийн дараалан даатгалын  
сангаас орвал төхижүүлтийн төтмийг түүчинд ирүүлж

Доров Ажил олгогч нь үйлдвэрлэлийн даатгалын  
даатгалын болон ажилтнээдийн даатгалын  
15 дугаар зуилийн 1, 5 дахь хослуудад энэхүү  
зохиц-шимигийн эхийн хувийн жилд төгвөртөй хөдлөлтэй  
байгууллагатай шимтгэлийн хөнгөлөлт тус тус үзүүлэхэд баримтална.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн  
2011 оны 11 дугаар сарын 24-ны өдрийн  
16 тоот тогтоолын хавсралт

## ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Энэхүү журмыг ажил олгогч болон даатгуулагчид Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт болон, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт тус тус үзүүлэхэд баримтална.

Хоёр. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, өгөгдлийн сангийн мэдээлэлд тулгуурлан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн болон ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт эдлэх ажил олгогч, даатгуулагчийн жагсаалтыг гаргаж, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд мэдэгдэх бөгөөд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

Гурав. Нийгмийн даатгалын зохих төрлийн санд төлөх шимтгэлийн хөнгөлөлт эдлэх шаардлагыг хангасан ажил олгогчид Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газрын "Талархал" хүргүүлнэ. "Талархал"-ын бичигт шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх үндэслэл, хөнгөлөлтийн хувь хэмжээ зэрэг мэдээллийг тусгасан байна.

Дөрөв. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь дээрх хоёр төрлийн санд төлөх шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээгээр уг сангийн шимтгэлийн орлогыг төслийн болон төсөөллийн жилүүдэд бууруулан төлөвлөх, хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн бүртгэл тооцоо, програм хангамжид өөрчлөлт оруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Тав. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх болзол, нөхцөл:

Үйлдвэрлэлийн ослыг багасгах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авсны үр дунд сүүлийн 3 жил дараалан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сангаас төлбөр (таксир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбоотой бусад төлбөрүүд) гаргуулаагүй байх;



Зургаа. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх болзол, нөхцөл:

Ажлын байрыг тогтвортой хадгалах замаар 5 жил дараалан ажилгүйдлийн даатгалын сангаас зардал (ажилгүйдлийн тэтгэмж, сургалтын зардал) гаргуулаагүй байх;

Долоо. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын болон ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсгүүдэд заасан ажил олгогчийн болон даатгуулагчийн төлбөл зохих шимтгэлийн хувь хэмжээг энэ журмын гурав дахь хэсэгт заасан хэмжээг үндэслэн тухайн жилд төлөх шимтгэлийг бууруулан төлж, холбогдох нийгмийн даатгалын байгууллагатай шимтгэл төлөлтийн тооцоо хийнэ.

Найм. Энэ журмын "Тав", "Зургаа" дахь хэсэгт заасан болзол, нөхцөлийг үргэлжлүүлэн хангасан тохиолдолд ажил олгогч, даатгуулагчид үзүүлэх хөнгөлөлтийн хувийг 10 хувиар нэмэгдүүлэн тооцох бөгөөд хөнгөлөлтийн дээд хэмжээ нь жилд төлөх шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

Ес. Энэхүү журмын хэрэгжилттэй холбоотой үүссэн маргаантай асуудлыг ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан зөрөөг хянан шийдвэрлэх үүрэг бүхий Нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөл шийдвэрлэх бөгөөд уг зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлж болно.

--- о О о ---

1. 201. онд ажил олгогчийн төлөх **ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЗСШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ**, 2. хувиар.

2. 201. онд ажил олгогчийн төлөх **АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ**, 2. хувиар.

Харвээ дээрх болзол, нөхцлийн түншлэлийн хангасан тохиолдолд ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлтийн дээрх хувь хийжтэй 10 хувиар нэмэгдүүлэн тооцох болно. Энэ тохиолдолд энэхүү хөнгөлөлтийн дээд хувийн нь жилд төлөх шимтгэлийн 50 хувийс хэтрэгтүй байна.

Танд эхлийн давхижүүлж хувье.

Сайн уйлс дээрээх болтугай

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР